



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/124

Сүхбаатар сум

Түнхэл, Бугант тосгодын хилийн цэсийг тогтоож,  
урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсэг томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "г", 29.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 51 тоот тогтоолоор батлагдсан "Багийн хөгжлийн хөтөлбөр"-ийн 7.1.2, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.4 дэх зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 51 тоот тогтоолоор батлагдсан "Багийн хөгжлийн хөтөлбөр", аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Бугант, Түнхэл тосгодын иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг тус тус үндэслэн Бугант тосгоны хилийн цэсийг тогтоож, урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, Түнхэл тосгоны хилийн цэсийг тогтоож, урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу Түнхэл, Бугант тосгодын хилийн цэсийг судалж, 2019 оны 5 дугаар сарын 13-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч Б.Нарантуяа, Ж.Сайнцог нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ



Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
2019 оны 04 -р сарын 09 -ны  
өдрийн 124 тоот захирамжийн  
1 дүгээр хавсралт

**БУГАНТ ТОСГОНЫ ХИЛИЙН ЦЭСИЙГ ТОГТООЖ, УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТ  
ГАРГАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Сайнцог

Аймгийн Засаг даргын хөгжлийн  
бодлогын асуудал хариуцсан орлогч

Нарийн бичгийн дарга:

Д.Эрдэнэбулган

Бугант тосгоны захирагч

Гишүүд:

Х.Мөнгөн

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын төлөөлөгч /Тохиролцсоноор/

Б.Саруултөгс

Газрын харилцаа, барилга, хот  
байгуулалтын газрын дарга

Б.Алтанзаяа

Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн  
хурлын дарга /Тохиролцсоноор/

М.Ганбаатар

Ерөө сумын Засаг дарга

Г.Цэнгэлзаяа

Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын Ойн албаны дарга

Б.Бямбадорж

Бугант тосгоны иргэдийн Нийтийн  
Хурлын дарга /Тохиролцсоноор/

З.Мөнхзаяа

Ерөө сумын газрын даамал

Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
2019 оны 04 -р сарын 09 -ны  
өдрийн 1124 тоот захирамжийн  
2 дугаар хавсралт

**ТҮНХЭЛ ТОСГОНЫ ХИЛИЙН ЦЭСИЙГ ТОГТООЖ, УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТ  
ГАРГАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Нарантуяа

Аймгийн Засаг даргын Гийгмийн  
бодлогын асуудал хариуцсан орлогч

Нарийн бичгийн дарга:

Ч.Оюунгэрэл

Түнхэл тосгоны захирагч

Гишүүд:

С.Раднаабазар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын төлөөлөгч /Тохиролцсоноор/

Б.Мөнхсоёл

Газрын харилцаа, барилга, хот  
байгуулалтын газрын Газрын  
удирдлагын хэлтсийн дарга

Б.Ганболд

Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн  
хурлын дарга /Тохиролцсоноор/

Н.Лхагвадорж

Мандал сумын Засаг дарга

З.Түвшинтөгс

Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын даргын үүргийг түр орлон  
гүйцэтгэгч

С.Эрдэнэ-Очир

Түнхэл тосгоны иргэдийн Нийтийн  
Хурлын дарга /Тохиролцсоноор/

Б.Булганхангай

/Мандал сумын газрын даамал/